

**“ЧОЙР ДЭД СТАНЦЫН ӨРГӨТГӨЛ, ШИНЭЧЛЭЛТ”**  
**ТӨСЛИЙН “БАРИХ-ШИЛЖҮҮЛЭХ” (ВТ) КОНЦЕССЫН ГЭРЭЭНИЙ**  
**НЭМЭЛТ ГЭРЭЭ**

2018 оны 06 дугаар сарын 29-ний өдөр

Улаанбаатар хот

Энэхүү нэмэлт гэрээ (цаашид “Нэмэлт гэрээ” гэх)-г Концессын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэг, Монгол улсын Засгийн газрын 2017 оны 103 дугаар тогтоол, Монгол улсын Үндэсний хөгжлийн газар болон “Алтай трест” ХХК-тай 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр байгуулсан Концессын гэрээ (“Концессын гэрээ” гэх)-ний 7 дугаар зүйлийн 7.3 дахь заалтыг тус тус үндэслэн нэг талаас Монгол улсын Засгийн газрыг төлөөлөн Засгийн газрын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар /цаашид “эрх бүхий этгээд” гэх/;

Нөгөө талаас Монгол улсын хуулийн дагуу үүсгэн байгуулагдсан “Алтай трест” ХХК /цаашид “Концесс эзэмшигч” гэх/ нар дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

**ҮНДЭСЛЭЛ:**

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 103 дугаар тогтоолын дагуу Монгол улсын тохируулагч агентлаг Үндэсний хөгжлийн газар болон “Алтай трест” ХХК-тай 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдөр “Чойр дэд станцын өргөтгөл, шинэчлэлт” төслийг хэрэгжүүлэх концессын гэрээг байгуулсан болно.

**НЭГ. НЭМЭЛТ ӨӨРЧЛӨЛТ**

1.1. Концессын гэрээний 2 дугаар зүйлийн холбогдох хэсгийг дараах байдлаар өөрчлөн найруулж байна. Үүнд:

“2.5. Концесс эзэмшигч нь 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор концессын зүйлийг бүрэн дуусгаж, улсын комиссод хүлээлгэж өгнө.” гэж;

“2.17. Концесс эзэмшигч нь 2018 оны 08 дугаар сарын 31-ний өдрийн дотор концессын зүйлийн барилга угсралтын ажлыг бүрэн дуусгаж, Монгол Улсын хууль тогтоомж болон Эрчим хүчний сайдын 2013 оны 98 тоот тогтоолоор батлагдсан “Эрчим хүчний тоног төхөөрөмж, барилга байгууламжийн угсралтын ажлыг ашиглалтад оруулах журам”-ын дагуу холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд заасан шаардлагын дагуу улсын комиссод хүлээлгэн өгч ашиглалтад оруулна” гэж тус тус өөрчлөх;

**ХОЁР. БУСАД ЗОХИЦУУЛАЛТ**

2.1. Энэхүү нэмэлт гэрээгээр өөрчлөлт оруулсан заалтуудаас бусад Концессын гэрээний зохицуулалт нь хүчин төгөлдөр хэвээр үйлчилнэ.

- 2.2. Энэхүү нэмэлт гэрээ нь талуудын эрх бүхий төлөөлөгчид гарын үсэг зурж, тамга тэмдэг дарсанаар хүчин төгөлдөр болох бөгөөд концессын гэрээний салшгүй хэсэг байна.
- 2.3. Нэмэлт гэрээ нь адил хүчинтэй 4 хувь үйлдэгдсэн бөгөөд концессын гэрээний адил хүчинтэй байна.

**ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:**

ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: Б.Баярсайхан  
Албан тушаал: Үндэсний хөгжлийн газрын дарга  
Тамга:



КОНЦЕСС ЭЗЭМШИГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Гарын үсэг:

Нэр: С.Баянчулуун  
Албан тушаал: "Алтай Трест" ХХК-ийн гүйцэтгэх захирал  
Тамга:

